



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН  
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2011 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 9

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Тус газрын “Дүрэм”-ийн 2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний тэргүүний аж ахуйн нэгж, байгууллага, хөдөлмөрийн аварга шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Уг тушаалыг мөрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавихыг Орлогч дарга /Ч.Энхсайхан/-д үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан тус газрын даргын 2006 оны “Түр журам батлах тухай” 71 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.


ДАРГА



П.НАРАНЦЭЦЭГ

050024

Нийтийн тээврийн газрын даргын  
2011 оны 1 дүгээр сарын 14-ний  
өдрийн... 9 дугаар тушаалын  
хавсралт



## НИЙТИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭРГҮҮНИЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ХӨДӨЛМӨРИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1 Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний тэргүүний аж ахуйн нэгж, байгууллага, инженер техникийн ажилтан, жолооч, кондуктор болон засварчныг шалгаруулж алдаршуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2 Шалгаруулалтанд нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд хамрагдана.

### Хоёр. Шалгаруулах төрөл.

2.1 Их, дунд багтаамжийн автобус, троллейбусаар үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудаас тэргүүний байгууллага нэг, хөдөлмөрийн аварга инженер техникийн ажилтан, жолооч, кондуктор, засварчин тус бүр хоёр хүнийг шалгаруулна.

2.2 Бага багтаамжийн автобусаар үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудаас тэргүүний байгууллага нэг, хөдөлмөрийн аварга инженер техникийн ажилтан, жолооч, кондуктор, засварчин тус бүр нэг хүнийг шалгаруулна.

2.3 Таксийн үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудаас тэргүүний байгууллага нэг, инженер техникийн ажилтан, жолооч, засварчин тус бүр нэг хүнийг шалгаруулна.

### Гурав. Шалгаруулах үзүүлэлтүүд.

#### 3.1 Тэргүүний байгууллага

Д/д	Шалгаруулах үзүүлэлтүүд	Оноо
1	Ажил үйлчилгээ эрхлэн гүйцэтгүүлэх гэрээг хугацаанд нь дүгнүүлж, гэрээний үүргийн биелэлт тогтмол 90 хувиас дээш байх	20
2	Шугамын цагийн тасалдалгүй ажилласан байх /85-аас дээш хувь/	10
3	Үйлчилгээний санал гомдол, ашиглалтын зөрчил, зам тээврийн осол, зөрчлийг бууруулах талаар үр дүнтэй ажил зохион байгуулж, гомдол, осол хэрэг, зөрчилгүй ажилласан байх.	15

4	Үйлчилгээний шинэлэг хэлбэр, техник технологи, туршлага нэвтрүүлж үр дүнд хүргэсэн байх.	10
5	Нийслэлийн бүтээн байгуулалт, тохижилтонд хувь нэмэр оруулж, байгууллага орчноо үлгэр жишээ тохижуулсан байх	5
6	Ажиллагсадын нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг өндөржүүлэх, ажлын байрны тоог нэмэгдүүлэх, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх	5
7	Тухайн жилд нийтийн тээврийн салбарт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж ажилласан байх	5
8	Өөрийн хөрөнгөөр хөдлөх бүрэлдэхүүний паркийн нөхөн хангалт хийсэн байдал	10
9	Тээвэрлэлтийн мэдээ тайланг хугацаанд нь чанартай гаргаж ирүүлсэн байх	10
10	Нийтийн тээврийн газраас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт /алба, хэлтсүүдээс санал авна/	10
Нийт дүн		100

### 3.2 Хөдөлмөрийн аварга жолооч

Д/д	Шалгаруулах үзүүлэлтүүд	Оноо
1	Тухайн жилийн ажлын цагийн фондыг бүрэн хангасан байх	20
2	Шугамын цаг, орлогын даалгаврыг сар бүр жигд ханган биелүүлсэн байх	20
3	Зогсоолын карманд зөв зогсож, буудал зарлаж хэвшсэн байх, үйлчилгээний санал гомдолгүй ажилласан байх	20
4	Үйлчилгээний санал гомдол, ашиглалтын зөрчилгүй ажилласан байх.	20
5	Зам тээврийн осол хэрэг гаргаагүй байх.	20
Нийт дүн		100

### 3.3 Хөдөлмөрийн аварга кондуктор

Д/д	Шалгаруулах үзүүлэлтүүд	Оноо
1	Тухайн жилийн ажлын цагийн фондыг бүрэн хангасан байх	20
2	Шугамын цаг, орлогын даалгаврыг сар бүр жигд ханган биелүүлсэн байх	20
3	Үйлчилгээний санал гомдолгүй ажилласан байх	20
4	Соёлч, шуурхай харьцаатай, зарчимч, шаардлагатай, үнэнч шударга ажиллаж, зорчигчдод хөнгөн шуурхай үйлчилсэн байх.	20
5	Үнэт цаасны зөрчил, дутагдал, өр төлбөргүй ажилласан байх	20
Нийт дүн		100

### 3.4 Хөдөлмөрийн аварга засварчин

Д/д	Шалгаруулах үзүүлэлтүүд	Оноо
1	Тухайн жилийн ажлын цагийн фондыг бүрэн хангасан байх	25
2	Засварт орсон автобус, троллейбусыг цаг хугацаанд нь шуурхай чанартай засварлаж ажлын гологдолгүй ажилласан байх	25
3	Сэлбэг материалын зардлыг хэмнэх талаар бүтээлч санаачлагатай ажиллаж, үр дүнд хүрсэн байх	25
4	Гэмт хэрэг, хэв журмын болон үйлдвэрийн осол, зөрчилгүй ажилласан байх	25
	Нийт дүн	100

#### 3.5 Тэргүүний инженер техникийн ажилтан

Хөдлөх бүрэлдэхүүний засвар үйлчилгээний технологийн зарчмыг мөрдүүлж хэвшүүлсэн, өртөг зардлыг бууруулах талаар шинэ бүтээл, оновчтой санал санаачилга гаргаж бодит үр дүнд хүрсэн, шугам замын болон техникийн саатал гаргаагүй байх.

#### Дөрөв. Дүгнэх.

4.1 Аж ахуйн нэгж, байгууллага нь шалгаруулах үзүүлэлтийн дагуу хийгдсэн ажил, хүрсэн үр дүнгийн талаар илтгэх хуудас, хөдөлмөрийн аваргаар тодорхойлсон ажилтны анкет, ажил байдлын тодорхойлолт болон шалгаруулалтын үзүүлэлтийн гүйцэтгэлийн талаар тодорхойлолтыг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор Нийслэлийн Нийтийн тээврийн газарт ирүүлнэ. Хугацаа хэтрүүлсэн материалыг хүлээн авахгүй болно

4.2 Аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн материалыг үндэслэн тухайн жилийн хөдөлмөрийн аваргад нэр дэвшүүлэх ажил мэргэжлийн болон тэргүүний байгууллагын саналыг Диспетерийн алба нь 1 дүгээр сарын 18-ны дотор Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

#### Тав. Шагнал, урамшуулал.

5.1 Тэргүүний байгууллагаар шалгарсан байгууллага тус бүрт Нийслэлийн Нийтийн тээврийн газрын даргын батламжилсан “Өргөмжлөл” дурсган, алдаршуулж 500,000 төгрөгийн мөнгөн шагналыг үйлчилгээний төрөл тус бүрээр олгоно.

5.2 Хөдөлмөрийн аваргаар шалгарсан ажилтан тус бүрийг Нийслэлийн Нийтийн тээврийн газрын даргын батламжилсан “Өргөмжлөл” дурсган алдаршуулж 200,000 төгрөгийн мөнгөн шагналыг аваргын төрөл тус бүрээр олгоно.

5.3 Шагнал, урамшуулалд зарцуулах мөнгөн хөрөнгийг тухайн аж ахуйн нэгж, байгууллага хариуцана.